

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 04 дүгээр сарын 14

Дугаар 41

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийг Төрийн дээд шагнал
“Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн”
одон медальд уламжлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит гуравдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Баянзүрх дүүрэг үүсэн байгуулагдсаны түүхт 60 жилийн ойг тохиолдуулан нийгэм, эдийн засаг, эрүүл мэнд, боловсрол, хүний хөгжлийг дэмжих, аюулгүй тав тухтай орчин, төрийн үйлчилгээг хурдан шуурхай үзүүлэх, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг тодорхойлох, хөгжил цэцэглэлтийг цогцлоож түүчээлэн ажилласан Баянзүрх дүүргийг төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн” одон медальд шагнуулахаар дэмжиж тодорхойлсугай.

2.Төрийн дээд цол хүртээх, одон медалиар шагнуулахаар тодорхойлж байгаа материалыг Нийслэлийн Засаг даргад хүргүүлэх, тогтоолын хэрэгжилтийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга (Г.Жаргалсайхан)-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (А.Уранбилэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ч.МЭНДСАЙХАН